

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2015 оны .. дугаар
Улаанбаатар
сарын ...-ны өдөр**

ХОТ

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.6 дахь хэсэг нэмсүгэй:

“19.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг 2015 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувь, 2016 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувь, 2017 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь, 2018 оны төсвийн жилээс эхлэн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.

2 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зарим хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг:

“19.1.Энэ хуулийн 6.1.2-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2018 оны төсвийн жилээс, 6.1.3-т заасан төсвийн тусгай шаардлагыг 2013 оны төсвийн жилээс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”

2/ 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн улсын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 60 хувиас, 2016 оны төсвийн жилд 55 хувиас, 2017 оны төсвийн жилд 50 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.”

3 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “2014 оны” гэснийг “2018 оны” гэж, мөн зүйлийн 19.6 дахь хэсгийн дугаарыг “19.7” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ